



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/267

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62, 64, 102 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн №22 дугаар хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн №23 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөлттэй холбогдуулан улсын хэмжээний цахим команд штабын дадлага сургууль зохион байгуулахад бичиг хэргийн зардал 417000 /дөрвөн зуун арван долоон мянга/, шатахууны зардал 391741 /гурван зуун ерэн нэгэн мянга долоон зуун дөчин нэгэн/ төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт дансны хандивын мөнгөнөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА